



## НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 06 сарын 27 өдөр

Дугаар А/31

Улаанбаатар хот

### Хагас жилийн эд хөрөнгийн тооллого хийх комисс байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70, 71, 73 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 12.2.1 дэх заалт, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1.Тус газрын үндсэн хөрөнгө, материалын 2023 оны эхний хагас жилийн тооллого хийх комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: Захиргаа, санхүүгийн хэлтсийн дарга  
Гишүүд: Хүний нөөц, ёс зүй дотоод ажил хариуцсан мэргэжилтэн  
Маркетинг сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн  
Агентлаг хариуцсан Ахлах нягтлан бодогч  
Архив, бичиг хэргийн эрхлэгч  
Агентлаг хариуцсан нярав

Нарийн бичгийн  
дарга: Жуулчны мэдээлэл сурталчилгааны төвүүд хариуцсан менежер

2.Тооллогын комиссын гишүүдийг мэргэжлийн удирдлагаар хангаж, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллахыг комиссын дарга (Д.Ганболд)-д даалгасугай.

ДАРГА: *D. Batm* Д.БАТСҮХ



115050175